

## СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ТҮҮНИЙ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2018 ОНЫ ТАЙЛАН



Илтгэгч: ИТХ-ын дарга Б.Энхбаатар

Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он

## СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ 2018 ОНД

2018 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар

- ❖ Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит хуралдаан 1, ээлжит бус хуралдаан 2 удаа хуралдаж 34 заалт бүхий 13 тогтоол
- ❖ Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 16 удаа хуралдаж 87 заалт бүхий 35 тогтоол гарган хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллаж байна.
- ❖ Сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд 65 албан бичиг ирж, аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал болон бусад байгууллагад 55 албан бичиг явуулж, хугацаатай 11 албан бичгийн хариуг хугацаанд хүргүүлсэн байна.
- ❖ Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны дундаж ирц 60.8 хувь.
- ❖ ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдааны дундаж ирц 62.8 хувьтай байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он

## 2018 ОНД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИД ХУРАЛДААНД ОРОЛЦСОН БАЙДАЛ

Д/д	ТӨЛӨӨЛӨГЧДИЙН НЭР	ХУРАЛД ОРОЛЦСОН ИРЦ /он, сар өдөр/			ХУРАЛД ОРОЛЦСОН ТОО
		2018.02.22	2018.07.23	2018.10.29	
1	Х.ГАНБОЛД	+	+	+	3
2	Н.АЛТАНХУНДАГА	+		+	2
3	Ц.ГОМБО	+	+	+	3
4	М.БЯМБАСҮРЭН	+	+	+	3
5	Д.ЭРДЭНЭЧУЛУУН				0
6	Л.ЯНЖИНДУЛАМ	+			1
7	Н.ТУУЛ				0
8	Д.ТӨРСАЙХАН	+	+	+	3
9	Б.ЭНХБААТАР	+	+	+	3
10	Б.ДАРАМСҮРЭН	+	+	+	3
11	Н.ЭНХБААТАР	+	+	+	3
12	Т.ПҮРЭВБААТАР	+	+	+	3
13	Ц.БАТДОРЖ	+		+	2
14	Л.ЭНХЖАРГАЛ		+		1
15	Г.ДАШЦЭРЭН		+		1
16	Л.ЛУТБАТ		+	+	2
17	Ш.БУЛГАМАА			+	1
18	О.МӨНХ-ЭРДЭНЭ				0
19	Б.МӨНХБАТ			+	1

Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он

## 2018 ОНД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД ХУРАЛДААНД ОРОЛЦСОН БАЙДАЛ

№	ТЭРГҮҮЛЭГЧДИЙН НЭР	ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛД ОРОЛЦСОН ИРЦ /он, сар өдөр/															
		01.25	01.29	02.06	03.05	03.06	04.05	04.18	05.09	06.11	07.06	07.09	09.20	10.15	11.21	11.30	12.11
1	Б.ЭНХБААТАР	★	★	★	★	★	★	★	★	★	★	★	★	★	★	★	16
2	Л.ЛУТБАТ	★	★	-	★	★	★	★	★	★	★	★	★	★	★	★	15
3	Т.ПҮРЭВБААТАР	★	★	★	-	-	★	-	-	★	★	★	★	★	★	★	11
4	Л.ЯНЖИНДУЛАМ	★	★	★	★	★	ө	ө	ө	ө	ө	ө	ө	ө	ө	ө	5
5	Д.ТӨРСАЙХАН	★	★	★	★	★	-	★	★	★	★	★	★	★	★	★	15
6	Б.МӨНХБАТ	★	-	★	-	★	-	★	-	-	-	-	-	-	★	-	5
7	Н.ЭНХБААТАР	★	-	-	-	-	★	-	★	★	-	-	★	-	-	-	5
ХУРАЛД ОРОЛЦСОН ТОО		7	5	5	4	5	4	4	4	5	4	4	5	4	5	4	
ХУРАЛД ОРОЛЦСОН ХУВЬ		100	71.4	71.4	57.1	71.4	57.1	57.1	57.1	71.4	57.1	57.1	71.4	57.1	71.4	57.1	
ӨВЧТЭЙ		-	-	-	-	-	1	1	1	1	1	1	1	1	1	1	
ЧӨЛӨӨТЭЙ		-	2	1	3	2	2	2	2	1	2	2	1	2	1	2	
ТАСАЛСАН		-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	

Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он

## Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын төлөвлөгөөнд нийт 34 ажил тусгаснаас :

- ИТХ-ын Ээлжит болон Ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлууд – 6
- Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудлууд – 10
- НӨУБ-ын үйл ажиллагааг нээлттэй, олон нийтийн оролцоог хангаж ажиллах талаар хийх ажлууд – 4
- Хяналт шалгалтын чиглэлээр – 4
- Дотоод ажил, сургалт сурталчилгааны чиглэлээр – 10 ажил тусгасан байна.


### Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсан 26 жилийн ой, Байгууллага сурталчилах 14 хоногийн аяны хүрээнд арга хэмжээний хүрээнд 2018 оны 01 дүгээр сард “Мөсний баяр”-ыг зохион байгууллаа. Мөсний баяраар Олс таталт, бухиа тэмцээн, мөсний шагайг зохион байгуулсан. Мөсний баярын тэмцээний нийлбэр дүнгээр

1-р байрыг А.Нарантуяа ахлагчтай Солонго цэцэрлэгийн баг

2-р байрыг Л.Хажидсүрэн ахлагчтай “Цогц-эрдэм” бүрэн дунд сургуулийн баг

3-р байрыг Г.Жасрайхүү ахлагчтай ЗДТГ-ын 3-р багууд орж баг тус бүрийг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнав.



### Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Б.Энхбаатар, тэргүүлэгч Л.Лутбат, Т.Пүрэвбаатар, Д.Төрсайхан, нарийн бичгийн дарга Н.Дэмбэрэл нар 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Эрдэнэцогт суманд баригдаж байгаа Витафит ХХК-ний сүү боловсруулах үйлдвэрийн барилгын явцтай танилцлаа.



Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Б.Энхбаатар, тэргүүлэгч Л.Лутбат, Т.Пүрэвбаатар, Д.Төрсайхан, нарийн бичгийн дарга Н.Дэмбэрэл нар Арьс нэхий боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцлаа. Энэ үйлдвэр нь хонины нэхийг элдэж боловсруулан эрэгтэй, эмэгтэй нэхий дээл хийх, мөн элдсэн нэхийгээ борлуулж байна. 1 элдсэн хонины нэхийг 35000 төгрөгөөр зардаг. Сум орон нутгаас бодлогоор дэмжиж Арьс нэхий боловсруулах үйлдвэрийн газрыг шинээр олгож, сум хөгжүүлэх сангаас зээл олгон дэмжиж ажиллаж байна. Н.Нямсүрэн нь 2018 онд Арьс нэхий боловсруулах үйлдвэрийн барилгаа шинээр барин үйл ажиллагаагаа тогтмолжуулан ажиллаж байна.



Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Б.Энхбаатар, тэргүүлэгч Л.Лутбат, Т.Пүрэвбаатар, Д.Төрсайхан, нарийн бичгийн дарга Н.Дэмбэрэл нар "Нутгийн удирдлагын ордон"-ы барилгын ажлын явц, гүйцэтгэлтэй танилцлаа. "Нутгийн удирдлагын ордон"-ы барилгыг Пүрэвсүрэн захиралтай "Зүүн шанд" ХХК барилгын ажлыг 07 дугаар сарын сүүлээр эхэлсэн ч ажлын гүйцэтгэл сайн явагдаж 12 дугаар сарын 26-нд өгөхөөр төлөвлөн ажиллаж байна.



Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он

### Аймгийн тахилгатай Эрхэтхайрхан тахилга болов.

Хангайн нурууны 2 дахь ноён оргил Эрхэт хайрхан тайх ёслолын арга хэмжээ 6 сарын 22-ны өдөр боллоо. Уг арга хэмжээнд аймгийн Засаг дарга, газар, хэлтсийн дарга нар, УИХ ын гишүүн Г. Занданшатарын бие төлөөлөгч, зарим сумдын удирдлагууд, Гачэн лам шавь нарын хамт хүрэлцэн ирж, төрийн тахилга, буян номын зан үйл хийн, эрийн гурван наадам зохион байгууллаа. Тахилга наадамаар үндэсний бөх, сурын харваа, хурдан морины уралдааныг зохион байгуулсан.



Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 54 дүгээр зарлигаар тус сумаас “Алдарт эх” нэгдүгээр зэргийн одонгоор Ямаат 2 дугаар багийн иргэн Зундуйн Дашдулам, Эрхэтхайрхан 5 дугаар багийн иргэн Дэмбэрэлийн Цэрэндэжид нар, “Алдарт эх” хоёрдугаар зэргийн одонгоор Сэнжит 1 дүгээр багийн иргэн Гүрбазарын Дэнсмаа, Ямаат 2 дугаар багийн иргэн Дагвын Бор, Шартолгойн Энхтуяа, Лхагвасүрэнгийн Нанжидмаа, Өвгөнжаргалант 3 дугаар багийн иргэн Дүйнхэржавын Золзаяа, Эрдэнэбаатарын Энхтуяа, Болдбаатарын Балтсүх, Жанжин 4 дүгээр багийн иргэн Адъяагийн Бурмаа, Эрхэтхайрхан 5 дугаар багийн иргэн Болоожийн Энхжаргал, Даваагийн Аюурзана, Цагаан дэнж 6 дугаар багийн иргэн Зийнаагийн Мөнхцэцэг, Халтарын Соёлмаа нар шагнагдлаа. Шагналыг сумын ИТХ-ын дарга Б.Энхбаатар, сумын Засаг дарга Ц.Төмөрбаатар нар 2018 оны 06 дугаар сарын 01-н буюу эх үрсийн баярын нээлтийн арга хэмжээн дээр гардууллаа.



Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он

2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Б.Энхбаатар багийн иргэдийн нийтийн хурлын дарга нартай хамтран ажиллах хариуцлагын гэрээ байгуулав. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанаас 2018 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр багийн иргэдийн нийтийн хурлын дарга нарт зориулсан сургалтыг зохион байгуулж гарын авлага бэлтгэн өглөө. Уг гарын авлага нь Засаг захиргааны анхан шатны нэгж буюу багийн иргэдийн нийтийн хурлын хууль эрх зүйн үндэс болох Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын Засаг захиргаа нутагт дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулинд заасан нэр томъёоны тухай ойлголт, багийн иргэдийн нийтийн хурлын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлогийг тайлбарласан гарын авлага юм.



Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он

## СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД БОЛОН ЭМЭГТЭЙ ТӨЛӨӨЛӨГЧИД СУРГАЛТАНД ОРОЛЦОВ.

Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран хэрэгжүүлж буй “Төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслөөс аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралтай хамтран зохион байгуулсан **“Аймаг сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийг чадавхжуулах сургалт”**-нд 2018 оны 04 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд сумын ИТХ-ын дарга **Б.Энхбаатар**, Тэргүүлэгч **Т.Пүрэвбаатар**, **Д.Төрсайхан**, **Л.Янжиндулам**, **Б.Мөнхбат** нар идэвхтэй оролцсон.

Мөн дээрх төслөөс зохион байгуулсан аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын эмэгтэй төлөөлөгчдийг чадавхжуулах **“Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал”** сургалтанд **Ш.Булгамаа**, **М.Бямбасүрэн** нар 2018 оны 05 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд оролцлоо.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он

### Аймгийн аварга малчдад хүндэтгэл үзүүлэв.

Ажил хөдөлмөрөөрөө бусдыгаа манлайлж аймгийн Аварга малчны болзлыг хангаж Аймгийн Аварга малчин болсон Сэнжит 1-р багийн малчин **М.Жаргалсайхан**, Өвгөнжаргалант 3-р багийн малчин **Д.Гантөмөр**, Жанжин 4-р багийн малчин **М.Чулуундорж**, мөн аймгийн аварга саальчин болсон Өвгөнжаргалант 3-р багийн саальчин **Д.Болормаа**, "Шинэ хот айл"-аар Жанжин 4-р багийн малчин **Д.Лхагвадоржийнх** шалгарч сумын удирдлагууд хүндэтгэл үзүүлж шагнал гардуулж өглөө.



Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он

## Р.Нармандах Улсын аварга малчин боллоо.

2018 оны 02-р сарын 12-нд Улсын Аварга малчин болсон Р.Нармандахын шагналыг УИХ-ын гишүүн, БОХХАА-н байнгын хорооны дарга Л.Элдэв-Очир, ИТХ-ын дарга Ц.Отгонбаяр, Засаг дарга Г.Батжаргал, ИТХ-ын дарга Б.Энхбаатар, Засаг дарга Ц.Төмөрбаатар, “Чандмань Баянхонгор” ХК-ний захирал Э.Энхбат болон бусад холбогдох албаны төлөөлөл Улсын Аварга малчны шагналыг гардуулан өглөө.



Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он

## Сумын аварга малчин, Алдарт уяач, шилдэг анчинд шагнал гардуулав.

Сумын хөдөө аж ахуйн аваргуудын шагналыг 2018 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Сумын ИТХ-ын дарга Б.Энхбаатар, Засаг дарга Ц.Төмөрбаатар, Засаг даргын орлогч Д.Цэвэгдорж, ЗДТГ-ын дарга Р.Болормаа нар хүндэтгэл үзүүлж шагналыг гардуулан өглөө. Сумын Аварга малчин, Алдарт уяач, оны шилдэг анчны шагналыг гардуулах арга хэмжээнд аймгийн шөф байгууллагууд болох аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Чандмань-баянхонгор ХК-ний захирал Э.Энхбат, Татварын хэлтэсийн дарга Д.Рэнцэндагва, аймгийн музейн захирал н.Мандах, Кап мон ББСБ-ын захирал Ариунжаргал, Авто-18 ХХК М.Мэндсайхан нар хүрэлцэн ирж баяр хүргэж, амжилт хүслээ.



Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он



2018 оны 02-р сарын 12-нд Алтан төлийн эзэн болсон Ц.Дамдинсүрэнд шагналыг УИХ-ын гишүүн, БОХХАА-н байнгын хорооны дарга Л.Элдэв-Очир, ИТХ-ын дарга Ц.Отгонбаяр, Засаг дарга Г.Батжаргал, ИТХ-ын дарга Б.Энхбаатар, Засаг дарга Ц.Төмөрбаатар, “Чандмань Баянхонгор” ХК-ний захирал Э.Энхбат болон бусад холбогдох албаны төлөөлөл Алтан төлийн эзэнд шагналыг гардуулан өглөө.



Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он

2018 оны 12 дугаар сарын байдлаар Монгол улсын Төрийн дээд шагнал “Хөдөө аж ахуйн гавъяат зүтгэлтэн”-д сумын Засаг дарга Ц.Төмөрбаатар, “Алтан гадас одон”-д Жанжин дүгээр багийн Улсын аварга малчин Д.Батболд, “Хөдөлмөрийн хүндэт” медальд Цагаандэнж 6 дугаар багийн өндөр настан Б.Лхагважав, Ц.Гомбо, С.Эрдэнэчимэг, Г.Юмчинсүрэн нарыг тодорхойлсон байна.



Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он

Монгол улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны ойн өдөрт зориулсан Монгол улсын Их хурлын даргын ивээл дор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах 6 дахь удаагийн тэмцээнийг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Сумын шатрын холбоо хамтран 2018 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулж нийт 14 шатарчин оролцож эрэгтэй, эмэгтэй 2 төрлөөр явагдаж эрэгтэй 1-р байрт Х.Батсайхан, 2-р байрт Д.Цэвэгдорж, 3-р байрт Б.Сүхбат, Эмэгтэй 1-р байрт Л.Одончимэг эзэлж шалгарсан шатарчид шатар сонирхогчдын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх мөнгөн шагналаар шагнагдлаа.



Иргэдийн төлөөлөгчдийн хурал – 2018 он

## ***АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА***